ХАСБАНК

ХАСБАНК ХК-ИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2026 оны 9-р сарын 30-ны байдлаар





ХАСБАНК

Агуулга

1. Онцлох үйл явдал 02-05
2. Санхүүгийн үзүүлэлтүүд 06-11
3. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд 12-13
4. Компанийн засаглал 14

Онцлох үйл явдал

ХАСБАНК

2026 оны III улирал

Apple Pay ХасБанканд нэвтэрлээ

ХасБанкны харилцагчид биет болон виртуал Visa картаа Apple Pay-д холбож, iPhone, Apple Watch зэрэг төхөөрөмжөөрөө хялбар, хурдан бөгөөд аюулгүй төлбөр тооцоо хийх боломжтой боллоо.



ХасБанкны биет Visa картаа Google Pay-д холбодог боллоо

Google pay үйлчилгээнд өмнө нь зөвхөн виртуал Visa карт холбох боломжтой байсан бол одоо ХасБанкны бүх төрлийн Visa дебит картаа холбон дэлхийн хаана ч төлбөр тооцоогоо хялбар, аюулгүй хийдэг боллоо.



InstaXpay шинэчлэгдлээ

InstaXpay дижитал хэтэвч шинэчлэгдэж, байр, цахилгаан, СӨХ-ийн төлбөрөө нэг дор төлөх, Асуудалгүй үйлчилгээний 500,000 төгрөгийн эрх нээх боломжууд нэмэгдлээ.



Онцлох үйл явдал

2026 оны III улирал



ЕСБХБ-тай зээлийн эрсдэл хуваалцах гэрээ байгууллаа

Зээлийн эрсдэл хуваалцах хөтөлбөрийн хүрээнд ХасБанкнаас шинээр олгох ЖДБ-ийн зээлийн эрсдэлийн 50 хүртэлх хувьд ЕСБХБ баталгаа гаргах бөгөөд хөтөлбөр нийт 25 сая еврогийн дүнтэй хэрэгжинэ.



Proparco-оос 40 сая ам.долларын санхүүжилт авлаа

COP17 хурлын үеэр Proparco хөгжлийн санхүүгийн байгууллагаас 40 сая ам.долларын санхүүжилт авах хэлцлийг амжилттай хийлээ. Тус эх үүсвэр нь ногоон үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих болон ЖДБ-үүдийг урт хугацаанд санхүүжүүлэх 3 чиглэлд зориулагдана.



Монголын Ногоон Санхүүгийн Корпорац нээгдлээ

Монгол Улсын Засгийн Газар, НҮБ-ын дэргэдэх Уур амьсгалын ногоон сан (УАНС) болон Монголын банк, санхүүгийн байгууллагуудын хамтын хөрөнгө оруулалттай тус корпорацид хөрөнгө оруулагчид нийт 50 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх бөгөөд УАНС ХасБанкаар дамжуулан хувь нийлүүлж, зээл болон техникийн туслалцааны санхүүжилт олгох юм.


Онцлох үйл явдал

2026 оны III улирал



ХасБанк COP 17 бага хуралд түнш байгууллагаар оролцлоо

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17-р бага хурал /COP 17/-ыг Улаанбаатар хотноо 2026 оны 8-р сарын 17-оос 28-ны өдрүүдэд зохион байгуулахад дэмжиж, хамтран ажиллалаа.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлагдлаа. 2026 оны 9-р сарын 17-оос 10-р сарын 9-ний хооронд эчнээ санал хураалт хэлбэрээр явагдах тус хурлаар ХасБанкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг шийдвэрлэнэ.



Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр

Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ХасБанкнаас хэрэгжүүлж буй нээлттэй зах зээлээс хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг 2026 оны 7-р сарын 23-аас эхлэн дахин 12 сарын хугацаанд хэрэгжүүлж байна.

Онцлох үйл явдал

ХАСБАНК

2026 оны III улирал



Хүлэгүүдийн шинэ замнал

2004 онд үүсгэн байгуулснаасаа хойш 22 жилийн хугацаанд тасралтгүй хамтран ажиллаж, Монголын сагсан бөмбөгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан, залуу үеийн үлгэр дуурайлал, хөгжөөн дэмжигчдийн бахархал болж, дээд лигийн аваргын алдрыг 10 удаа хамтдаа хүртсэн Хасын Хүлэгүүд баг болон ХасБанкны хамтрал өндөрлөж, Хасын Хүлэгүүд баг бие даасан хөгжлийнхөө дараагийн шинэ үе шатанд шилжлээ.



Lexus Cup 2026

Гранд Тигрэ клубээс жил бүр зохион байгуулдаг “Lexus Cup 2026” талбайн теннисний нээлттэй тэмцээнийг 2 дахь жилдээ ивээн тэтгэж хамтран ажиллалаа. Энэ жилийн тэмцээнд давхардсан тоогоор 622 тамирчин оролцож, эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан болон хосын төрөлд аваргуудаа шалгаруулсан юм.



Kharkhorum Festival

Хөгжим, дижитал урлаг, дэвшилтэт технологиор залуусыг нэгтгэж, 8 зууны тэртээ эзэнт гүрний төв байсны адил өнөөдөр соёл урлаг, электрон хөгжмийн Ази дахь бас нэгэн төв болохоор жилээс жилд өргөжин тэлж буй Kharkhorum Visual Art & Music Festival-ыг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа.

Санхүүгийн үр дүн

2026 оны III улирал

Цэвэр ашиг	ROE
₮50.2 тэрбум	20.5%

XAC (Хувьцаажаа ханш)	EPS
₮1,678	₮175.8

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
18.9%	43.3%

Ашигт ажиллагаа

- 2026 оны III улиралд ХасБанкны татварын дараах ашиг 50.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, өссөн дүнгээр цэвэр ашиг 134.4 тэрбум төгрөг буюу өмнөх жилийн мөн үеэс 10.8% өссөнөөр нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) 175.8 төгрөгт хүрлээ.
- Тайлант хугацаанд үйл ажиллагааны нийт орлого 116.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 15.9 хувиар өссөн ба үүнд зээл болон хөрөнгө оруулалтын багцын тэлэлтээс шалтгаалсан хүүгийн цэвэр орлогын өсөлт голчлон нөлөө үзүүлжээ.
- Зардлын удирдлагыг сахилга баттай хэрэгжүүлсний үндсэнд зардал орлогын харьцаа үзүүлэлтийг тогтвортой буюу 37.1 хувьд (2025 оны эцэст 37.3 хувь байсан) барьж ажиллаа..
- Өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 20.5 хувьд хүрч өмнөх улирлаас 0.5 суурь нэгжээр өссөн байна.

Баланс

- Нийт хөрөнгө өмнөх улирлаас +17.8% өсөж 8,846 тэрбум төгрөгт хүрсэн бол хүүгийн орлого олдог актив өмнөх улирлаас +16.8% өсөж, 7,678 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт хөрөнгийн 87 хувийг бүрдүүлж байна. Үүнд зээлийн багцын зэрэгцээ үнэт цаасны үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн.
- III улиралд зээлийн багцын өмнөх улирлаас 0.8 хувиар буурч 4,850 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сегмент болон зээлийн бүтээгдэхүүнээр задлан харвал харилцан адилгүй буюу Лизингийн багц 2.5 хувиар өсөж 876 тэрбум төгрөг, бичил ЖДБизнэсийн зээл 3.4 хувиар өсөж 1,508 тэрбум төгрөгт хүрсэн бол байгууллагын банкны зээлийн багц 5.3 хувиар буурч 890 тэрбум төгрөг, хэрэглээний зээлийн багц 1.6 хувиар буурч 1,072 тэрбум төгрөг, ипотекийн зээлийг МИК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор 8.0 хувиар буурч 505 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.
- Активын чанар сайн хэвээр буюу нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт 2.2 хувьтай байна. Өмнөх улиралтай харьцуулахад харьцаа үзүүлэлт өөрчлөгдөөгүй боловч чанаргүй зээлийн үлдэгдэл 1.2 тэрбум төгрөгөөр буурч 104.7 тэрбум төгрөг байна.
- Нийт харилцах, хадгаламж хурдацтай өсөж 5,131 тэрбум төгрөгт хүрч, өмнөх улирлаас 28.5 хувиар өссөн байна. Ийнхүү нийт харилцах, хадгаламж өссөнөөр зээл болон хадгаламжийн харьцаа үзүүлэлт өмнөх улирлаас буурч 94.5 хувьд хүрсэн байна.
- 2026 оны III улиралд ХасБанк гадаад эх үүсвэр татах ажиллагаа амжилтай үргэлжилж ЕСБХБ-с 40 сая ам.доллар, Symbioitics-с 9.5 сая ам.доллар, DWM-с 5 сая ам.долларыг тус тус татан төвлөрүүлсэн ба нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 647 сая ам.долларт хүрсэн байна.

Харьцаа үзүүлэлт


- 2026 оны III улирлын байдлаар Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд зохих хэмжээнд байна.
- 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 18.9 хувь буюу доод хэмжээг 6.4 нэгж хувиар давуулан биелүүлсэн байна.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2026 оны 9 сарын 30-ны байдлаар 43.3 хувьтай байгаа нь зохистой харьцааг хангаж байна.

Санхүүгийн үзүүлэлтийн тренд

2026 оны III улирал


Цэвэр ашиг

Тэрбум төгрөг




Нийт актив

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгийн өгөөж

Сүүлийн 12 сарын дундаж өөрийн хөрөнгөөр тооцов.



1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа



Зээлийн үйл ажиллагаа

2026 оны III улирал

Нийт зээлийн тоо	Онлайн зээлийн тоо	Иргэдийн банк зээлийн тоо	Байгууллагын банк зээлийн тоо	Бизнесийн банк зээлийн тоо	ХасЛизинг с.түрээсийн тоо
209.4мянга ▲ +0.3% QoQ	**136.8**мянга ▲ +1.1% QoQ	**202.8**мянга	**0.2**мянга	**0.4**мянга	**6.1**мянга

Зээлийн багц

Тэрбум төгрөг




Зээлийн багц

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг




Дотоод эх үүсвэр

2026 оны III улирал

Нийт дансны тоо	Харилцах дансны тоо	Хадгаламжийн дансны тоо	Нийт харилцагчдын тоо
1.6сая ▲ +1.1% QoQ	**1,009.7мянга**	**563.2мянга**	**1,187.3мянга** ▲ +0.8% QoQ


Харилцах, хадгаламж

Тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрлөөр

Тэрбум төгрөг



- Нийт харилцах болон хадгаламжийн үлдэгдэл 5,168 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 28.4 хувиар өссөн байна.
- Тайлант хугацаанд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн харилцах дансны үлдэгдэл нэмэгдсэн нь дотоод эх үүсвэрийн үлдэгдэл өсөхөд голчлон нөлөөлсөн байна. ААН-үүд ХасБанкаар дамжуулан төлбөр тооцоо хийх, бэлэн мөнгөний удирдлагаа оновчтой зохион байгуулахад шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон ажиллаа.


Гадаад эх үүсвэр

2026 оны III улирал

Тайлант хугацаанд Банк олон улсын банк санхүүгийн байгууллагууд болох ЕСБХБ-с гэрээний эхний олголт болох 40 сая ам.доллар, Symbiocits-с 9.5 сая ам.доллар, DWM-с 5 сая ам.доллар , нийт 64.5 сая ам.доллартой тэнцэх төгрөгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн байна. Нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 9 сарын байдлаар 647 сая ам.долларт хүрч өмнөх улирлаас 24 сая ам.доллараар өссөн байна. ЕСБХБ-тай нийт 80 сая ам.долларын гэрээ байгуулсан ба үлдсэн хэсэг болох 40 сая ам.долларыг 2027 онд татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Гадаад эх үүсвэрийн үлдэгдэл

Сая ам.доллар



Шинээр гадаад эх үүсвэр олгосон байгууллагууд

40 сая ам.доллар

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бичил, жижиг дунд бизнес болон ногоон төслүүдийг дэмжих зорилгоор Proparco санхүүгийн байгууллагатай 40 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулаа.

9.5 сая ам.доллар

2026 оны III улиралд бичил, жижиг дунд бизнесийг санхүүжүүлэх зорилгоор 9.5 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийг амжилттай татлаа.

5 сая ам.доллар

Мөн нэмэлтээр DWM-ээс бичил, жижиг дунд бизнесийн зээлийн өсөлтийг дэмжих зорилгоор төгрөгийн санхүүжилт авсан.

Хувьцааны мэдээлэл


2026 оны III улирал

ХасБанк ХК (ХАС)-ийн хувьцааны үнэ 2026 оны 9 сарын 30-ны өдөр 1,678 төгрөгөөр хаагдаж, өмнөх оны мөн үеийн хаалтын ханшаас 90.7 хувь, IPO хийсэн үнээс 147.9 хувиар өслөө. ХАС-ийн IPO хийснээс хойших нийт өгөөж (хувьцааны үнийн өсөлт болон ногдол ашгийн өгөөжийн нийлбэр) 2026 оны III улирлын байдлаар 167.5% байна.

ХасБанк ХК жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг холбогдох зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны нийт халаасны хувьцаа 9 сарын 30-ны өдрийн байдлаар 2,853,223 ширхэгт (нийт эргэлтэд гаргасан хувьцааны 0.27%) буюу 2026 оны 2 сараас хойш өөрчлөгдөөгүй байна.

2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар ТУЗ санал болгосон байна. Ногдол ашгийг 10 сарын 9-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (EGM)-ын санал хураалтын үр дүнд үндэслэн тараахаар хүлээгдэж байна.


ХАС хувьцааны ханш, нэгж хувьцаанд ногдох өөрийн хөрөнгө



* - 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгийг жилд хөрвүүлэн тооцов.

Ногдол ашиг хуваарилалт

Тэрбум төгрөг



** - IPO ханш буюу нэгж хувьцааны ханш 677 төгрөгт үндэслэн тооцов.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд


2026 оны III улирал

1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

18.9% Байвал зохих доод хэмжээ 12.5%

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

43.3% Байвал зохих доод хэмжээ 25.0%





Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал	2026 I улирал	2026 II улирал	2026 III улирал
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15%	-4.9%	-0.6%	-1.2%	-3.5%	6.6%	-1.7%
Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30%	-5.7%	-1.4%	-1.2%	-4.9%	6.9%	-2.9%
Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа <300%	46.3%	51.8%	54.8%	53.2%	75.1%	77.0%
Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8%	1.1%	1.1%	1.1%	1.1%	1.0%	0.9%
Хадгаламжийн төвлөрлийн харьцаа <25%	6.8%	6.9%	8.0%	7.6%	8.1%	18.4%

	2025 II улирал	2025 III улирал	2025 IV улирал	2026 I улирал	2026 II улирал	2026 III улирал
Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.9%	1.0%	2.0%	0.9%	0.7%	0.6%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%	0.1%
Банкны бусад холбогдох этгээд	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.1%	0.1%
Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй):						
Банкны хувьцаа эзэмшигчид	0.9%	1.0%	2.0%	1.0%	0.7%	0.6%
Банкны эрх бүхий албан тушаалтан	0.4%	0.4%	0.3%	0.3%	0.3%	0.2%
Банкны бусад холбогдох этгээд	0.1%	0.1%	0.1%	0.0%	0.1%	0.1%

Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хорооны хурал

2026 оны III улирал

Төлөөлөн удирдах зөвлөл

2	1	9	5
Хурал	Цахим санал хураалт	Тогтоол	Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Засаглал, цалин урамшууллын хороо

1 удаагийн хурал
1 удаагийн цахим санал хураалт

Эрсдэлийн удирдлагын хороо

1 удаагийн хурал
10 удаагийн цахим санал хураалт

Нэр дэвшүүлэх хороо

1 удаагийн хурал

Аудитын хороо

3 удаагийн хурал

ХасБанк ХК-ийнТөлөөлөнудирдахзөвлөлийн 2026 оны 08 дугаарсарын 20-ны өдрийн R-2026-38 дугаар тогтоолоор Хувьцааэзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Тус хувьцааэзэмшигчдийн ээлжит бус хурлаар ХасБанкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах тухайа суудлыг хэлэлцэнэ. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж байна.

ХАСБАНК

(976)-75771888-(888)

investor-relations@xacbank.mn

https://www.xacbank.mn

